

445

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙЦААГЧ,  
МЭРГЭЖИЛТЭН Г.ГАРАМХАНДЫН 2024 ОНЫ 11-12 САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
АЖЛЫН ТАЙЛАН**

Тус сумын Нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтэн Г.Гарамханд миний бие нь Төв аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 6/45 дугаар тушаалаар Эрдэнэ сумын нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтнээр томилогдож 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр томилогдсон суманд ажил хүлээлцэх комиссын хамт ажил хүлээлцэж үүрэгт ажлаа хүлээж авсан.

Тус саруудад өндөр насны 8, тэжээгчээ алдсаны 1 тэтгэврийн материалыг тус тус бүрдүүлж хувийн хэрэг үүсгэж тэтгэвэр тогтоолгохоор аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлж шийдвэрлүүлж шинээр тэтгэвэр тогтоолгосон.

Тэтгэвэр дутуу орсон 5 хүний хүсэлтийг хүлээн авч шалган шийдвэрлүүлж тэтгэврийн дутууг олгосон.

Өндөр нас, ХЧА-ын тэтгэвэр авч байгаад нас барсан тэтгэвэр авагчийн нийт 4 оршуулгын тэтгэмж, 3 хүний дараа сарын материалыг бүрдүүлж шийдвэрлүүлж олгогдсон.

Ажилгүйдлийн тэтгэмж 4 хүний хүсэлт материалыг хүлээн авч холбогдох материалыг бүрдүүлэн шийдвэрлүүлсэн.

Жирэмсэн амаржсаны 2 тэтгэмжид зөвөлгөө өгч нийгмийн даатгалын цахим сайтаар илгээж шийдвэрлүүлсэн.

Тэтгэвэр авдаг 3 өндөр настны банк солиулах хүсэлтийг хүлээн авч холбогдох материалыг бүрдүүлэн банк шилжүүлсэн.

Сайн дурын даатгалд хамрагдсан нийт даатгуулагчдын жагсаалтыг хуулгаар түүвэрлэн шалган гаргаж үүнээс малчин, 0-3 настай хүүхдээ асарч байгаа эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хийдэггүй эх, эцэг, энгийнээр төлсөн даатгуулагчдын жагсаалт гаргасан. Мөн мөнгөө төлсөн боловч гэрээ хийгдээгүй СДД-д хамрагдсан нийт 95 малчин, энгийн төлөлттэй 23 даатгуулагчийн гэрээг цахимаар байгуулсан.

Тэтгэвэр авагч 4 иргэний Төрийн банкаас Хаан банк руу тэтгэвэр шилжүүлэх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын зөвөлгөө, мэдээлэл шаардлагатай нийт 400 орчим иргэдэд цахимаар, биечлэн болон утсаар холбогдож шаардлагатай мэдээллийг хүргэсэн.

2024 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан “Команд штабын сургууль”-д нийт сумдын байцаагч, мэргэжилтнүүдийн хамт зүүм, фэйсбүүк, утсаар холбогдож хамрагдсан.

Суманд үйл ажиллагаагаа явуулдаг нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ААН-тэй тогтмол утсаар холбогдож төлөлт хийхийг сануулан, шаардаж ажилласан.

Хүний нөөцийн мэргэжилтнээс ирүүлсэн шагналын судалгаа, цагийн баланс бусад мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн.

ГЛАВАМХАНД



ДААТГАЛЫН БАЙЦААГЧ, МЭРГЭЖИЛТЭН

ЭРДЭНЭ СУМЫН НИЙГМИЙН

ТАЙЛАН БИЧЭН:

Орон нутгаас зохион байгуулсан урлаг соёл, спортын арга хэмжээг тэмцээн уралаанад тодорхой амжилт гаргаж оролцсон, нийтийг хамарсан пэвэрлэгээ үйлчилгээнд идэвхтэй хамрагдсан.

Орон нутгаас сар бүр зохион байгуулдаг байгууллагын дарга удирдлага, мэргэжилтнүүдийн тайлангийн хуралд сарын хийсэн ажлуудаа тухай бүр тайлагнаж ажигласан.

Сүм орон нутгаас 12 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд зохион байгуулсан хүн ам, малын тооллогог оролцож ажигласан.

**Бусад:**

Аймагас зохион байгуулсан пал үеийн зүүм сургалт, мэдээлэл тухай бүр холбогдож хуралд хамрагдсан.

11 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, сүүмандээ эрүүл мэндийг даатгалын зөвөлгөө мэдээллийг иргэдэд үзүүлж ажиглаж байна. Нийт 35 иргэнийг зөвөлгөө мэдээлээр хангаж, эрүүл мэндийн даатгалыг төлүүлсэн.

24/4